



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 21/648

Булган сум

**“Булган мээж” ОНӨХХК-тай гэрээ  
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Сангийн сайдын 61 дүгээр тушаалын хавсралт Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV хуралдааны XXV/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын 2024-2025 оны халаалтын улиралд дулаан үйлдвэрлэх, түгээх, дамжуулах ажлыг хэвийн явуулахад шаардлагатай мөнгөн хөрөнгийг эргэн төлөх нөхцөлтэйгөөр гэрээ байгуулж олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Булган мээж” ОНӨХХК-тай гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д үүрэг болгосугай.

3. Шаардлагатай 500,000,000 (таван зуун сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010897